

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТОГТООЛ**

2019 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар  
хот

**Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай**

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн 12 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч”-ийн Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний “Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг” гэсэн хэсэгт “2. Төрийн худалдан авах ажиллагааны газар” гэж нэмсүгэй.

2. “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2016 оны 12 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч”-ийн “Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг” гэсэн хэсгийн “2, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12, 13, 14, 15, 16, 17, 18, 19, 20” дахь дугаарыг “3, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12, 13, 14, 15, 16, 17, 18, 19, 20, 21” гэж тус тус өөрчилсүгэй.

3. Төрийн худалдан авах ажиллагааны газрыг Монгол Улсын Ерөнхий сайдын батлагдсан төсөв, орон тооны хязгаарт багтаан байгуулж ажиллуулахыг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т даалгасугай.

**ГАРЫН ҮСЭГ**